НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр Дугаар А/1202 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх Цахим Улаанбаатар төслийн ажлын жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т, шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 4,890,000,000 (дөрвөн тэрбум найман зуун ерэн сая) төгрөгийг "Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын "24.1.2"-ын "38"-д заасан ""Цахим Улаанбаатар" төсөл"-ийн хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (Б.Даваанням)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

1110205181

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
10 дугаар ..... сарын 04-ны өдрийн
А/402 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЦАХИМ УЛААНБААТАР ТӨСЛИЙН АЖЛЫН ЖАГСААЛТ

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Хэсгийн ахлагчийн систем нэвтрүүлэх	2023	2023	613.0	613.0
2	Digital UB гар утасны аппликейшны хөгжүүлэлт	2023	2023		
3	Онлайн бизнес төвийн нэмэлт хөгжүүлэлт	2023	2023	530.7	530.7
4	UB ERP системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажил	2023	2023	150.0	150.0
5	Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн сайжруулалт, мэдээлэл солилцох боломжийг бий болгох ажил	2023	2023	250.0	250.0
6	Дата төвийн өргөтгөл, шинэчлэлт, аюулгүй байдал, хяналтын систем	2023	2023	3,046.3	3,046.3
7	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон төрийн бусад байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, Нийслэлийн дата төвд түшиглэн системийн энтерпрайз архитектур боловсруулах	2023	2023	300.0	300.0
Дүн				4,890.0	4,890.0